НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ

"СЭЛЭНГИЙН ИРЭЭДҮЙ- ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ"

СУМ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ:

Сэлэнгэ аймгийн Орхон сум анх 1943 онд Төв аймгийн Жаргалантын САА-н Үнэгтийн контор нэртэй МАА-н фермд тулгуурлан Орхон дахь хонь үржүүлгийн аж ахуй байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлжээ. 1959 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гаргасан БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 222-р зарлигаар Сэлэнгэ аймгийн Орхон сум байгуулагдсан. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хувьд Орхон, Бэлэндалай гэсэн 2 багтай. 685 өрхөд 2301 хүн амьдардаг.

Орхон сум

99728089

http://orkhon.se.gov.mn/

Сэлэнгэ аймгийн Баруун урд хэсэгт оршдог. Улаанбаатар хотоос 220 км, аймгийн төвөөс 180 км, Дархан-уул аймгаас 70 км, Орхон аймгаас 110 км зайд байрладаг.

Тус сум нь Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумтай баруун урд, Баруунбүрэн сумтай баруун, Сант сумтай баруун хойд, Сайхан сумтай зүүн хойд, Баянгол сумтай зүүн урд, Төв аймгийн Сүмбэр сумтай зүүн урд хэсгээр тус тус хиллэдэг.

Сумын төв нь Дархан, Эрдэнэтийн замаас 4 км зайтай оршдог бөгөөд төв зам хүртэл асфальтан замтай, үүрэн холбооны шугам сүлжээнд бүрэн холбогдсон нь зам харилцаа, холбооны давуу тал юм. Төр, төсвийн байгууллагууд болоод сумын төвийн айл өрхүүд нэгдсэн халаалтад холбогдсон ба дэд бүтцийн хувьд эрчимтэй хөгжиж байна. Цаашид өндрийн усан сан, цэвэрлэх байгууламжтай холбогдох суурь нөхцөл бүрдээд байна.

ТУС СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

Орхон сум нь газар тариалан, мал ахуйн чиглэлээр аж ахуй эрхлэгч иргэд, аж ахуй нэгж олонтой бөгөөд газар тариалангийн зориулалтаар ашиглагддаг нийт 27132 га эргэлтийн талбайтай ба 100 хувь ашиглаж байна. Цаашид эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Эрчимжсэн мал аж ахуй
- Мал бордох үйлдвэрлэл
- Тэжээлийн аж ахуй
- Гахай, тахиан фермерийн аж ахуй
- Нарийн ногооны хүлэмжийн аж ахуй зэрэг болно.

ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ БОЛОН ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖИЛ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ:

Хийгдэж буй ажил, арга хэмжээ:

- Өндрийн усан сан
- Цэвэрлэх байгууламж
- "Агро парк" хүлэмжийн аж ахуй

Хийгдэхээр төлөвлөж буй ажил, арга хэмжээ:

- Үхрийн эрчимжсэн аж ахуй
- Мал бордох үйлдвэрлэл
- Арьс шир боловсруулах үйлдвэрлэл зэргийг гадаад дотоодын байгууллага, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар хамтран байгуулах суурь нөхцөл бололцоо нь бүрдсэн байна.

ТАНАЙ СУМЫГ ЗОРИН ИРЭХ ИРГЭДЭД ЯМАР БОЛОМЖ НӨХЦӨЛ ОЛГОХ ВЭ?

Сум орон нутгийг зорин шилжин ирэх иргэд сумын төр, төсвийн байгууллагуудад ажиллах нээлттэй бөгөөд нарийн мэргэжлийн албан хаагчдыг орон байраар хангах мөн төрийн захиргааны албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор цалингийн орон нутгийн нэмэгдлийг 60 хувьд хүргэхээр зорьж байна. Мөн суурьшлын бүсэд гэр бүлийн хэрэгцээ, өрхийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар газрыг шийдвэрлэн олгох боломжтой. Газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр сум орон нутгийн захиргааны байгууллага, иргэд, аж ахуй нэгжтэй хамтран ажиллахад нээлттэй бөгөөд таатай орчин бүрдсэн.